

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/069/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 51-260512 Цахим хаяг: <a href="mailto:enkhdalaid@audit.gov.mn">enkhdalaid@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Ц.Энхжаргал Утас: 51-261628 Цахим хаяг: <a href="mailto:enkhjargalts@audit.gov.mn">enkhjargalts@audit.gov.mn</a></p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Цахим хаяг: <a href="mailto:dabg.audit@gmail.com">dabg.audit@gmail.com</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1095  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлын онцлон тэмдэглэсэн хэсэг

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК нь үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр агаарын тээврийн түрээсийн АегСар компаниас В787-9 төрлийн онгоц урт хугацааны түрээсээр ашиглах гэрээ байгуулж, 2 дахь онгоцоо 2024 оны 4 дүгээр сард хүлээн авч Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 16-д нийцүүлэн тайлагнасан байна.

Гүйцэтгэх захирлын 2024 оны А/407 дугаар тушаалаар Агаарын хөлгийн түрээсийн бүртгэлийг СТОУС 16-д нийцүүлэн бүртгэхтэй холбоотой хөрөнгө ашиглах эрхийн элэгдлийн бүртгэлд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 заалт, НББОУС 16-д нийцүүлэн компанийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулсан байна.

### Асуудлын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж,

аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 94 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 488 дугаар тогтоолын дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, Хөшигтийн хөндийн Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудал дахь Агаарын хөлгийн засвар үйлчилгээний газрын 53 нэр төрлийн 137,921.7 сая төгрөгийн барилга, байгууламжийг балансаас балансад шилжүүлэн авч бүртгэсэн байна.

Олон улсын агаарын тээврийн холбооны зорчигч тээвэрлэлтийн ерөнхий дүрмийн 11.6.1 дэх заалт, Гүйцэтгэх захирлын 2018 оны А/543 дугаар тушаалаар баталсан “Ашиглаагүй тийзийн өглөгийг компанийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх журам”-ын дагуу ашиглагдаагүй 2 жилийн хугацаа хэтэрсэн 15,647.5 сая төгрөгийн зорчигч, ачаа тээврийн өглөгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК нь 2024 онд нийт 4,225 нислэг, үүнээс 2,472 хуваарьт, 689 орон нутгийн, 870 Ханбумбат чиглэлийн захиалгат, 79 бусад захиалгат, 115 карго нислэгийг үйлдсэн байна. Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг “Монголд зочлох жил” болгон зарласнаар нислэг тээвэрлэлт нэмэгдэж, суудал ашиглалт өссөн, 2024 онд дундаж суудал ашиглалт 80.0 хувьтай байна гэж тайлагнажээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	20,290,815,197.34	29,414,101,192.54
1.1.2	Дансны авлага	38,173,202,856.54	54,902,233,958.06
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	17,946,555,890.09	21,047,959,798.33
1.1.4	Бусад авлага	3,151,681,159.74	1,722,187,808.33
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	27,260,732,748.70	-
1.1.6	Бараа материал	49,462,605,064.74	59,711,915,244.80
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	26,998,765,318.18	31,252,130,804.07
1.1.8	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>183,284,358,235.33</b>	<b>198,050,528,806.13</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	103,339,234,895.76	266,080,212,498.42
1.2.2	Биет бус хөрөнгө	3,829,945,400.32	5,953,316,994.62
1.2.3	Хойшлогдсон татварын хөрөнгө	20,018,150,704.87	20,018,150,704.87
1.2.4	Бусад эргэлтийн бус хөрөнгө	412,534,927,272.62	566,131,022,675.78
1.2.5	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>539,722,258,273.57</b>	<b>858,182,702,873.69</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>723,006,616,508.90</b>	<b>1,056,233,231,679.82</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	50,453,258,471.07	71,338,128,268.53
2.1.1.2	Цалингийн өглөг	1,218,378,713.00	1,298,490,218.00
2.1.1.3	Татварын өр	16,177,354,900.32	18,591,429,865.24
2.1.1.4	Богино хугацаат зээл	38,204,899,993.15	37,749,988,000.00
2.1.1.5	Хүүний өглөг	245,484,762.83	270,241,012.95
2.1.1.6	Урьдчилж орсон орлого	74,084,659,275.30	87,644,788,258.50
2.1.1.7	Бусад богино хугацаат өр төлбөр	905,714,499.86	855,483,353.39
2.1.1.8	Богино хугацаат түрээсийн өр	42,355,311,909.14	71,486,418,163.07
2.1.1.9	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>223,645,062,524.67</b>	<b>289,234,967,139.68</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	17,749,984,000.00	19,999,996,000.00
2.1.2.2	Бусад урт хугацаат өглөг	3,654,951,542.01	4,085,218,849.71
2.1.2.3	Урт хугацаат түрээсийн өр	343,420,479,194.80	457,738,181,903.93
2.1.2.4	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>364,825,414,736.81</b>	<b>481,823,396,753.64</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>588,470,477,261.48</b>	<b>771,058,363,893.32</b>
2.3	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: а) төрийн	5,577,283,000.00	5,577,283,000.00
2.3.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,585,133,420.50	10,585,133,420.50
2.3.3	Эздийн өмчийн бусад хэсэг	2,376,716,050.49	132,255,956,516.19
2.3.4	Хуримтлагдсан ашиг	115,997,006,776.43	136,756,494,849.81
2.3.5	Өмнөх үеийн үр дүн	63,474,505,004.77	124,273,714,340.02
2.3.6	Тайлант үеийн үр дүн	52,522,501,771.66	12,482,780,509.79
2.3.7	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>134,536,139,247.42</b>	<b>285,174,867,786.50</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>723,006,616,508.90</b>	<b>1,056,233,231,679.82</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>814,311,570,713.07</b>	<b>941,183,631,669.56</b>
2	Борлуулалтын өртөг	681,512,177,255.17	829,564,519,196.20
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>132,799,393,457.90</b>	<b>111,619,112,473.36</b>
4	Түрээсийн орлого	56,253,733.15	26,959,199.40
5	Хүүний орлого	2,443,912,490.50	1,496,041,692.97
6	Бусад орлого	16,175,908,899.01	6,088,942,753.65
7	Борлуулалт, маркетингийн зардал	478,623,810.16	592,220,355.42
8	Ерөнхий ба удирдлагын зардал	33,988,813,595.61	40,231,885,536.48
9	Санхүүгийн зардал	28,734,434,033.70	48,995,879,462.92
10	Бусад зардал	12,864,830,765.71	129,869,442.31
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(8,920,854,403.06)	(6,247,467,280.67)
12	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
13	Бусад ашиг (алдагдал)	-	-
14	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>66,487,911,972.32</b>	<b>23,033,734,041.58</b>
15	Орлогын татварын зардал	13,965,410,200.66	10,550,953,531.79
16	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>52,522,501,771.66</b>	<b>12,482,780,509.79</b>
17	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>52,522,501,771.66</b>	<b>12,482,780,509.79</b>
18	Орлогын нийт дүн	52,522,501,771.66	12,482,780,509.79
19	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	52,522,501,771.66	12,482,780,509.79

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>850,330,810,937.29</b>	<b>965,182,408,246.42</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	849,330,701,270.01	959,955,272,640.84
1.1.2	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	9,223,905.60	3,606,699,944.37
1.1.3	Бусад мөнгөн орлого	990,885,761.68	1,620,435,661.21
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>827,244,459,345.69</b>	<b>974,219,437,019.79</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	60,977,214,536.20	76,008,827,012.56
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	14,525,000,000.00	19,871,328,821.95
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	9,285,054,123.95	11,397,964,486.24
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	598,215,079.87	300,148,464.49
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	309,430,564,004.11	388,025,141,968.62
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	6,501,108,713.61	3,481,341,415.49
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	36,201,225,837.50	16,258,233,685.34
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	9,029,788,901.07	11,656,494,675.99
1.2.9	Бусад мөнгөн зарлага	380,696,288,149.38	447,219,956,489.11
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>23,086,351,591.60</b>	<b>(9,037,028,773.37)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>2,723,686,667.36</b>	<b>29,296,997,077.70</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	799,845,472.54	-
2.1.2	Хүлээн авсан хүүний орлого	1,923,841,194.82	2,036,264,329.00
2.1.3	Хадгаламж	-	27,260,732,748.70
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>26,519,078,104.98</b>	<b>9,128,909,646.38</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,258,345,356.29	8,160,980,232.38
2.2.2	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	967,929,414.00
2.2.3	Хадгаламж	22,260,732,748.69	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(23,795,391,437.62)</b>	<b>20,168,087,431.32</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>54,000,000,000.00</b>	<b>40,000,000,000.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	54,000,000,000.00	40,000,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>66,106,656,423.28</b>	<b>66,106,656,423.28</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	66,106,656,423.28	38,204,899,993.16
3.2.2	Төлсөн ногдол ашиг	-	2,626,125,090.00
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(12,106,656,423.28)</b>	<b>(831,025,083.16)</b>
4	Валютын ханшийн өөрчлөлтөө үүссэн ашиг (алдагдал)	(1,953,104,627.84)	(1,176,747,579.59)
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(14,768,800,897.14)</b>	<b>9,123,285,995.20</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>35,059,616,094.48</b>	<b>20,290,815,197.34</b>
7	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>20,290,815,197.34</b>	<b>29,414,101,192.54</b>

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	<b>15,651,158,561.09</b>	<b>2,376,716,050.49</b>	<b>51,486,181,426.58</b>	<b>75,091,339,038.16</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	11,988,323,578.19	11,988,323,578.19
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	<b>15,651,158,561.09</b>	<b>2,376,716,050.49</b>	<b>63,474,505,004.77</b>	<b>87,079,662,616.35</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(5,066,025,140.59)	-	-	(5,066,025,140.59)
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	52,522,501,771.66	52,522,501,771.66
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	<b>10,585,133,420.50</b>	<b>2,376,716,050.49</b>	<b>115,997,006,776.43</b>	<b>134,536,139,247.42</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	8,276,707,563.59	8,276,707,563.59
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	<b>10,585,133,420.50</b>	<b>2,376,716,050.49</b>	<b>124,273,714,340.02</b>	<b>142,812,846,811.01</b>
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	129,879,240,465.70	-	129,879,240,465.70
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	12,482,780,509.79	12,482,780,509.79
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	<b>10,585,133,420.50</b>	<b>132,255,956,516.19</b>	<b>136,756,494,849.81</b>	<b>285,174,867,786.50</b>

**2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/сая төгрөг/

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	1. Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	888.2	1,225.1	1,153.0	(72.1)	94.1
	1.1 Тогтмол нислэгийн зорчигч тээвэрлэлт	мян.хүн	648.3	1,023.4	885.9	(137.5)	86.6
	1.2 Захиалгат нислэгийн зорчигч тээвэрлэлт	мян.хүн	239.9	201.7	265.0	63.3	131.4
	2. Ачаа тээвэрлэлт (шуудан+ачаа)	тонн	9,448.9	12,621.6	12,589.0	(32.6)	99.7
	3. Зорчигч эргэлт	сая.хүн.км	2,256.6	3,154.9	2,751.5	(403.4)	87.2
	4. Ачаа эргэлт	сая.тн.км	34.5	49.8	49.3	(0.5)	99.0
	5. Шилжүүлсэн тонн-километр	сая.тн.км	251.2	370.1	309.9	(60.2)	83.7
2	<b>6. НИЙТ ОРЛОГО</b>	сая.төгрөг	<b>832,987.6</b>	<b>1,089,482.2</b>	<b>948,795.6</b>	<b>(140,686.7)</b>	<b>87.1</b>
	6.1 Агаарын тээврийн үндсэн үйл ажиллагааны орлого	сая.төгрөг	775,249.7	1,052,836.8	868,718.9	(184,117.9)	82.5
	6.2 Үндсэн бус болон үйл ажиллагааны бус орлого	сая.төгрөг	57,737.9	36,645.5	80,076.7	43,431.2	218.5
3	<b>7. НИЙТ ЗАРДАЛ</b>	сая.төгрөг	<b>766,499.7</b>	<b>1,059,160.8</b>	<b>925,758.1</b>	<b>133,402.7</b>	<b>87.4</b>
	<b>7.1 Агаарын тээврийн үндсэн үйл ажиллагааны зардал</b>	сая.төгрөг	739,583.2	1,027,037.5	913,914.4	113,123.1	89.0
	7.1.1 Үндсэн үйл ажиллагааны зардал	сая.төгрөг	698,267.9	980,724.6	871,770.8	108,953.8	88.9
	7.1.2 Ерөнхий удирдлага, нэмэгдэл зардал	сая.төгрөг	41,315.4	46,312.9	42,143.6	4,169.3	91.0
	- Ерөнхий нэмэгдэл зардлын дүн (захиргаа, удирдлага)	сая.төгрөг	33,281.8	40,531.8	35,482.8	5,049.0	87.5
	- Зээлийн хүү	сая.төгрөг	5,669.5	3,481.1	3,506.1	(25.0)	100.7
	- Үндсэн хөрөнгийн элэгдэл (агаарын хөлгөөс бусад)	сая.төгрөг	2,364.1	2,300.0	3,154.7	(854.7)	137.2
	<b>7.2 Үндсэн бус болон үйл ажиллагааны бус зардал</b>	сая.төгрөг	17,995.6	24,426.9	5,596.3	18,830.6	22.9
	Үндсэн ажиллагааны ашиг (алдагдал) валютын ханшийн алдагдлыг оруулахгүйгээр	сая.төгрөг	<b>75,098.8</b>	<b>38,017.8</b>	<b>29,284.9</b>	<b>8,732.9</b>	<b>77.0</b>
	7.3 Валютын ханшийн зөрүүгийн бодит олз, гарзын хэлбэлзэл	сая.төгрөг	16,139.6	7,696.4	2,106.6	5,589.7	27.4
7.4 Валютын ханшийн зөрүүгийн бодит бус олз, гарзын хэлбэлзэл	сая.төгрөг	(7,219.0)	-	4,140.8	(4,140.8)	100.0	
4	<b>8. Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	сая.төгрөг	<b>66,487.9</b>	<b>30,321.4</b>	<b>23,037.4</b>	<b>7,284.0</b>	<b>76.0</b>
	- Татвар тооцогдох үйл ажиллагааны ашиг (алдагдал)	сая.төгрөг	58,959.2	30,321.4	27,178.3	3,143.2	89.6
5	<b>9. Орлогын албан татвар</b>	сая.төгрөг	<b>13,965.4</b>	<b>7,130.4</b>	<b>10,551.0</b>	<b>(3,420.5)</b>	<b>148.0</b>
6	<b>10. Цэвэр ашиг (алдагдал)</b>	сая.төгрөг	<b>52,522.5</b>	<b>23,191.0</b>	<b>12,486.5</b>	<b>10,704.5</b>	<b>53.8</b>
7	11. Төсвийн нийт төлбөр	сая.төгрөг	55,325.0	33,998.2	39,735.5	(5,737.3)	116.9

**“Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын хураангуй тайлан**

8	12. Төрийн өмчийн ногдол ашиг	сая.төгрөг	-	-	2,626.1	(2,626.1)	100.0
9	13. Нийт ажилчдын тоо	хүн	1,058	1078	1,078	-	100.0
10	14. Нийт цалингийн сан	сая.төгрөг	61,455.1	75,973	77,805.8	(1,832.8)	102.4
11	15. Дунда цалин	сая.төгрөг	4,840.5	5,873.0	5,199.5	673.5	88.5
12	16. Орлогын нэг төгрөгт ногдох зардал	төгрөг	0.92	0.97	0.98	(0.0)	101.0
13	17. Хөрөнгө оруулалт	сая.төгрөг	17,600.3	57,713.7	47,819.3	9,894.4	82.9
14	18. Нийт авлага	сая.төгрөг	59,585.5	57,454.0	77,903.2	(20,449.2)	135.6
15	19. Нийт өглөг	сая.төгрөг	588,470.5	672,295.0	771,058.4	(98,763.4)	114.7
16	Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	сая.төгрөг	227,300.0	240,065.0	293,320.2	(53,255.2)	122.2
17	Урт хугацаат өр төлбөр	сая.төгрөг	361,170.5	432,230.0	477,738.2	(45,508.2)	110.5

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл, тооцоолол болон тайлагналтай холбоотой 372,177.3 сая төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн залруулга хийлгэсэн.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Дд	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
								Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн байдлын тайланд хэрэгжээгүй нэмэгдсэн өртгийн албан татварын авлага дансанд 2008-2022 онуудад үүссэн 211.0 сая төгрөгийг илүү тайлагнасан.	1	211.0			1	211.0	1	211.0				
2	Орлогын дэлгэрэнгүй тайлан, ААНБОАТ-ын тайлангуудын орлогын дүнгээс Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангаарх нийт орлогыг 368,186.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	368,186.7	1	368,186.7			1	368,186.7				
3	Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын худалдан авалтын и-баримтыг бүрэн бүртгээгүйгээс Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангаарх нийт зарлагыг 3,779.6 сая төгрөг дутуу тайлагнасан байна.	1	3,779.6			1	3,779.6	1	3,779.6				
<b>Дүн</b>		<b>3</b>	<b>372,177.3</b>	<b>1</b>	<b>368,186.7</b>	<b>2</b>	<b>3,990.6</b>	<b>3</b>	<b>372,177.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

/сая төгрөгөөр/

“Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын хураангуй тайлан

3.2 Аудитаар илрүүлсэн нийт 5,242.3 сая төгрөгийн 8 зөрчлөөс 226.7 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч, 5,015.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 албан шаардлага хүргүүлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 704 дүгээр тогтоолоор баталсан компанийн Эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшний төлөвлөгөөнд ажлын байрны 169 түр орон тоог батлуулаагүй, цалингийн зардлыг төлөвлөгөөнөөс 1,978.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	1	1,978.5			1	1,978.5				
2	Ажилтан, албан хаагчдын авлагын дансны үлдэгдэлд 11 хүний 83.0 сая төгрөгийг хугацаа хэтэрсэн, он дамжсан авлагын үлдэгдэлтэй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	83.0			1	83.0				
3	Авлага дансны үлдэгдэлд тайлагнасан 5 байгууллагын 1,610.9 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	1,611.0			1	1,611.0				
4	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2005 оны 333 дугаар тогтоолоор нэр бүхий байгууллагад автобаазын зориулалттай газар эзэмших эрхийг шилжүүлж, орон сууц барих зориулалттай газар эзэмших эрхийг шилжүүлэн авч балансаас балансад бүртгэсэн байна. Шилжүүлэн авсан газрыг автобаазын зориулалтаар ашиглахаар өөрчлөөгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	-			1	-				
5	Тайлант оны санхүүгийн тайланд нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад татварын өр төлбөрийг татварын цахим системийн үлдэгдлийн тодорхойлолтоос 1,343.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	1,343.1			1	1,343.1				
6	Бараа материалын дансанд 27.7 сая төгрөгийн 391 ширхэг автомашины сэлбэг хэрэгсэл, 28.2 сая төгрөгийн 2 нэр төрлийн маягт, нийт 55.7 сая төгрөгийн илүүдэл нөөц бэлтгэсэн нь ашиглах боломжгүй, цаг үеийн хоцрогдолд орсон, хөрөнгө үр ашиггүй болсон байна.	1	55.7					1	55.7		
7	Компанийн биет бус хөрөнгийн дансанд газар, санхүүгийн болон нисэх үйлдвэрлэлийн үйл ажиллагааны программ	1	-					1	-		

**“Монголын иргэний агаарын тээвэр” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын хураангуй тайлан**

	хангамж, бусад биет бус хөрөнгүүдийг төрлөөр нь ангилан бүртгээгүй, хөрөнгийн шинж чанаргүй 1 жилийн хугацаатай 1.9 сая төгрөгийн лицензийн төлбөр хураамжийг хөрөнгөөр бүртгэсэн байна.										
8	Гадаад сургалтын төлөвлөгөөний гүйцэтгэл нь 34.3 хувьтай байна. Төлөвлөгөөнд батлагдаагүй 29.0 сая төгрөгийн сургалтад ажилтнуудыг хамруулсан, 142.0 сая төгрөгийн сургалтыг хугацаанд нь зохион байгуулаагүй цуцалсан зэрэг гүйцэтгэл хангалтгүй байна.	1	171.0					1	171.0		
<b>Дүн</b>		<b>8</b>	<b>5,242.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>5,015.6</b>	<b>3</b>	<b>226.7</b>	<b>-</b>	<b>-</b>

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудиттай холбоотой зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
1	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих нийт 170 мэдээнээс Байгууллагын батлагдсан төсөв, Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар, ХАА-ны төлөвлөгөө, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концесын зүйлийн жагсаалт гэсэн нийт дөрвөн мэдээг хугацаа хоцроож өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	-			1	-			
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт										
2	Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулахаар баталсан 1,685.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ажлыг шууд худалдан авсан байна.	1	-			1	-			
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>